

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Авирмэдийн Батхүү	Дугаар	L244
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Мандал-Овоо сум
Төрсөн газар	Мандал-Овоо сум	Төрсөн он	1937
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шар хулсны хийд	Сүм хийдийн дугаар	ӨГМО 004
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Шар Хулснын хийд

Гантулга: За та энэ Шар Хулстын хийдийн талаар товч мэдээлэл өгнө үү?

Батхүү: За баярлалаа. Шар Хулсны хийд гэдгийг дээхэн үед байгуулсан юм гэнэ лээ, би 1937 онд төрсөн хүн. Тэрнээс өмнө хийд яваад ,байгаад лам хуваргууд хийдийн тухайд нэлээн хүндрэлийн байдал хүрээд, монгол орон даяар хэлмэгдлийн үед багтаад энэ хийдийн бүрэн байдал, аж байдлын талаар би мэдсэн юм байхгүй ээ. Гэхдээ 1948 онд би энэ Шар Хулсны хийд дээр бага сургуульд 2-р ангид ирж суралцахад дуган, одоо цогчин дуган нь гээд байсан нь агуулах болчихсон, тэгээд ойр зуурын шавар гэрэн байшингууд нь нурсан. Иймэрхүү нэг үгээр сүүлийн үеийн монгол хэлээр бол түүр болчихсон хэмжээнд дөхчихсөн байсан. Одоогийн байдлаар бол тэрнээс нэлээн дордчихсон. Яг одоо бол шавар овоонууд болчихжээ хүүхдүүд минь. Энэ талаар бол цааш нь би мэдлэг бага юм. Зүгээр дам сонссон , аав ээж ахас дээдсээс сонсоход манай энэ Шар Хулсны хийд бол хойшоо Онгийн хийд Хошуу хийддээ захирагддаг юм уу, дүү хэмжээгээр. Урагшаа явах юм бол Ханын цагаан суварганы лам нар энэ хийд дээр ирдэг байсан. Дээшээ явахлээр Онгийн дээд уулын, Онгийн доод хийдийн ер нь хойд талын хийдүүд ахалж явдаг ,лам нар нь дээд талд нь гардаг, ийм байсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

түүхтэй. Энэ бол унаа малаар, хороондоо холбоо хэлхээ ярилцдаг ийм байсан байгаа юм.Тодорхой шашны сургуулиуд, энэ бол шарын шашны замаар явж байсан, энэ бол тодорхой.Шарын шашин гэдэг бол монголд нэлээн дээр үеэс дэлгэрсэн болов уу гэсэн санаа байдаг юм.Зүгээр түүх шастирч та бүхэн мэднэ биз тэр талаар бол, миний хэлэх юм алга аа.Нэлээн тодорхой энэ манай Балгасын хийдүүдээр сургууль соёлын хэмжээгээр ч гэдэг юм уу, бөөгнөсөн шавь нарын байдал явагдаагүй.Нэгэн хоёр ламын хоёр гурван банди хойчийг залгамжилж ном судар үзэж байсан болов уу гэсэн бодол надад төрдөг юм. Ийм ч байдаг тухай яригддаг юм.Зүгээр энд жаахан шавилан сууя гэсэн , хойшоо Онгийн хошуу хийдэд сурцгаадаг байсан гэсэн ийм юм би сонссон.Манай энэ дээр одоо хамгийн том ловон лам нь ч ямар лам байсан юм, зүгээр мэдэх юм алга.Энэ дээр дооромбо лам гэж одоо хамгийн хүндтэй, тэгээд эмч.Энэ бол тэр үедээ хамгийн гол эмч, ерөөсөө дооромбо ламын өвдсөн барьсан асуух юмыг дооромбо лам дээр ирдэг.Энэ хүнийг Төвд хүн байсан юм гэнэ лээ.Гучин зургаан оны үеэр, таван оны үеэр ч юм уу, дөрвөн онд ч юм уу эсэргүү хэргээр гадаадын хүн гээд л бариад явсан юм гэнэ лээ.Тэгээд устсан.Тэрний хоёр гурван шавь нар байж байгаад тэгээд үлдсэн, юу нас өөд болсон доо зайлуул.Тэгээд дооромбо ламын сайн эмчилдэг чадлаас би нэг хоёр хүнээс дуулсан юм, би ярья л даа.Манай энд нэг сайн анчин хүн байдаг юм байна. Тэрнийг харчихаад таныг үхтэл чинь ангаар амьдардаг байлгая. Үхтэл чинь хараатай байлгая гэж хоёр том эм, хонины элгэнд нухаад, түүхий элгэнд нухаад үмхүүлчихсэн гэж байгаа юм.Шар Сумъяа гэдэг хүнд, тэгээд тэр хүн бол хоёр зовхи нь бүүчихсэн өвгөн хүн.Ная шахаж явсан хүн үү, гарсан ч байсан уу.Тэгээд зовхио шүдэнзний модоор тэвхлээд энэ урд гол дээр намар гөрөөс усанд ороход, шүдэнзний модоор нүдээ тэвхлээд, зовхио тэвхлээд буудаад ирээд ооно үүрээд ирж байсан гэж байгаа юм.

Гантулга: Тийм хараа сайтай?

Батхүү:Тийм хараатай болгож л үхүүлсэн.Тэгээд сарын дараа тэр хүн өөд болсон түүхтэй.Нөгөө нэг нь бол тэр дооромбо лам энэ баруунтаа морь уургалаад морь нь үлийд онхолдож байхад эмээлийг нь бүүрэглээд эрээ шаазанги нь өвдөөд, манай энд Цэрэндорж гэж байсан.Тэр хүн ирээд үзүүлсэн гэж байгаа юм.Тэгсэн ганц судас барьж үзчихээд өө цөс чинь хагарч нэг түн эм өгчихөөд, дахиад нэг түн эм боож өгч за чи хариад долоо хоног энийг нэг жаахан болгоо.Ханиах байх ханиахад чинь амаас чинь хавтгай ногоон паалан шиг эд гурав, дөрөв гарах болов уу.Сайн тоолж сайн харж байгаарай, тэгээд гарчих юм бол зүгээр болно, цөс чинь хагарсан байна гэж байгаа юм.Тэгээд л нөгөө дэх хариад л цаадахыг нь нэг тав зургаан хоног уусан, тэгээд ханиадаг.Ханиахаар амнаас нь хавтгай ногоон паалан шиг юм гарч байсан.Тэгээд зүгээр болсон.Тэгээд одоо зээ хүүгээ өвөртөлж ингээд сургууль тарж байхад, хүү нь шаралчихсан, өвөртөлж унтаад байсан.Эмч нар хүү дээр нь орж ирж битгий хүүхэд өвөртөл, та шарлана гэсэн нөгөө хүн эмчид хэлэхгүй юу.Би цөс байхгүй ээ, шарлах учиргүй, өвөртөлж унтсаар байгаад одоо энэ Баянмөнх гэж хүү байна.Эдгээж байж байсан.Тэгэхээр сайн лам гэдэг тийм олон жил, энийг дуулсан хүн ч байна, дуулаагүй хүн ч байна.Хүү Цэрэндорж гэж тэр ахмад өвгөнөөс өөрөөс нь дуулсан.

Гантулга: Хүү Цэрэндорж гэдэг нь?

Батхүү: Тэр цөс нь хагарсан хүн байхгүй юу.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Хүү гэдэг нь бол зүгээр л тийм?

Батхүү: Аа нэг тийм юм.

Гантулга: Энэ Шар хулсын хийдийн тэдэн онд байгуулсан, тийм хүн байгуулсан нь?

Батхүү: Энэ талаар мэдэх юм байхгүй.1948 онд Ханын цагаан суварга дээр Мандал Овоо сум сумлагдаад байсан.Тэнд бол тэнхимд, Тэнхим гээд сургуульд очиход мөн ийм дуган дотор байрлаж хичээллэж байсан.Тэгээд дөчин найман онд энд нүүж ирээд, харин дуган дотор байрлаагүй, гэрт хичээллэж байсан.Тэгээд л ирэхэд энэ дээр чинь хэдэн шавар дуган байсан, одоо дов болжээ, шавар болж...

Гантулга: Энэ ойролцоох сүм хийдүүдийн талаар та бас түрүүн дурдлаа?

Батхүү: Аа тийм.

Гантулга: Дацан сургууль, лам нар нь ирж очдог гээд, тэрээн дээр нэмж хэлэх зүйл байвал?

Батхүү:Манайх чинь зүүнтээ өргөрөгөөрөө явбал зүүн тийшээ Олдохын хийд гээд байна.Эндээс одоо нэг зуун тавиад км-т багтаж байна.Энэ тэгээд хошуугаа дагасан шуу хийд нэг байсан юм болов уу., галбын говийн гурван хийд, Байшинтын хийд бол энэ Түшээ гүний, биш ээ, Балдан Засгийн хошуунд харъяаглагдаж байсан болов уу.

Гантулга: Говийн гурван хийд гэдэгт нь ямар ямар хийд?

Батхүү:Аа энэ Дэнтийн хийд орж байна, Байшинтын хийд орж байсан юм болов уу, нэг нь тэр овоо хийд ямар юмны хийд билээ орж байсан, говийн гурван хийд гэж.Тэгээд энэ хийдүүдэд түшиглэсэн нэг зүйл нь яахав дээ тэр номын чадал ч байдаг юм уу, ном бол чадалтай байсан гэж ярьж байгаа хүн ч бий.Яахав хийд балгас, бариад шавар байшин бариад овоолохоосоо гадна тэр хийдэд байсан эрдэмтэдийн тэр номыг л олж сурах нь их чухал юм гэж би боддог юм.Тэгээд юу хэлэх гээд байгаа юм гэвэл энэ баруун Онгийн гол дагуудаа ямааны годрон гараад, хаяа хүрээд ирлээ хүүе болохоо байлаа.Өнөө годрон чинь хар усанд ирсэн гэнэ шүү. Энэ өмнө гол дээр бүтээлийн товог гэж байдаг юм.Бүтээл бүтээлгүй болохгүй гээд нэг хэсэг лам нар цуглаад тэр голын өмнө уулзаж байгаад, тэр чинь ийм овоо байгаа юм, тэрэн дээрээ бөөн шовгор юм байгаа юм.Тэр шовгор дээр бүтээлийн товог дээр цуглаж байгаад ном уншчихсан.Тэгээд л хоёр гурван хоноод л ямааны годрон ч сураггүй болсон, тэр бол энгүй их хамгаалдаг товог гэж байгаа юм. Тэр ном нь ямар ном байдаг мю, би мэдэхгүй.

Гантулга: Аль юуны хажууханд гэнэ ээ?

Батхүү: Үгүй ээ тэр овооны гол дээр л , тэр тахилгатай овооны дэргэд л .

Гантулга: Тахилгатай овооны хажууд уу?

Батхүү:Тахидаг овооны тахилгын хажууд жаал толгой дээр , зүгээр нэг ийм үргэлж. Эндээс одоо тэр ногоон долвонгийн хэртэй л газар байна.Тэрэн дээр нь бүтээл бүтээгээд л тэр ямааны годрон сураггүй болсон.Тэгээд л ...

Гантулга: Аль хийдийн лам нар нь?

Батхүү: Өө тэр Дэнтийн хурал байх. Дэнтийн лам нар ирээд л ном уншсан. Мал их жирхэдчихээд одоо ингээд малын жирх бөөс болчихоод байж байгаа нөхцөлд олон ном уншина.Тэгээд л хонио тэр цасан дээр хурааж байхад гэрт хүн ном уншиж байна.Тэгэхэд л тэр гадаа хураачихсан, одоо би бүр багадаа хурааж байсан гээд хүн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ярьж байгаа юм.Тэгээд л гэрт ном уншаад л за хот руу оруул гэхэд цас нь ингээд л хар болоод л үлдэж байсан .Жирхнүүд нь хар болгоод.Энд одоо Цэдэнхүү , Балжиннямын авгай Цэдэнхүү гэж байж байгаад нас барсан.Тэр хурааж байсан гэж, одоо байвал нэг наяд гарсан л хүн байх ёстой байсан, өөд болсон л доо.Тэгээд ном чадалтай байсан гэдгийг Дамдинсүрэн гуай ч хэлж байсан.Өвчин бүгдийг алга болгодог байсан юм , одоо тэр ном алга болсоор байгаад, чадалтай номыг уншиж чаддаг хүн байвал чадалгүй яахав гэж хөөрч байгаа юм.Энэ их өртөг үнээр зарахгүйгээр тэр номоор хүчин чадлыг нь зардаг, тийм нөхцөлийг нь олж авч чадвал энэ хийд барилгаасаа илүү л юм байна та минь гэсэн санаа л надад бодогддог юм л даа.

Гантлуга: Одоо эрдэм, ухаан?

Батхүү:Тийм, ухаан чадал номын тэрүүнд нь.Түүгээр ч барахгүй одоо энэ хийд бараадаж байсан улсууд чадал суудаг юм уу, манай говьд бий тэнгисийн академич болсон гэхээр нь би энэ дээр очлоо л доо. Манай аймагт нэг Батням гэж, тэнгисийн академич болсон хүн байгаа юм.Энэ Олдохын хийдийн өндөр хөх лам Чүлтэмдорж гэж байсан байгаа юм.Аа энэ Байшинтын хийдийн дарга шар лам Содномдаржаа гэлүү? Содномдорж гэлүү, за тэр хоёрын нэг,Содномоор л эхэлдэг юмдаг.Тэр хоёр хүнийг эсэргүү лам гээд барьж авчраад буудсан гэж байгаа юм.Сум даагаагүй.Тийм учраас тэр хоёр хүнийг амьдаар нь , Гурвансайханы жалганд яг амьдаар нь буулж алсан.Тэгээд манай говьд бол сум даадаггүй баатар Сандуй баатар, биш ээ Санги баатар гэж, ийм ноёны говийн.Энэ бол сум даадаггүй хүн.Ингээд одоо энэ гоийн нөхцөлд би амьдралын хугацаанд сонсоход гурван, сум даадаггүй гурван баатар байжээ.Тэгээд дандаа тэр лам нар хийд дагаж байсан, номын чадал байсан уу, сум даахгүй хүн гэж яаж ч байсан, дуулчаад надад зарим нь захиж байгаа юм.Би үзээгүй учраас дуулснаа ярьж байна, энэнийг надад ярьдаг хүн хэн бэ гэхлээр надад ярьсан хүн энэ Дэлгэрхангай суманд байж байгаад нас барсан Мятавдорж гэдэг өвгөн.

Гантулга: Дундговийн Дэлгэрхангай сум уу?

Батхүү: Дундговийн Дэлгэрхангай сумын Мятавдорж.Хүү нь Далайхүү гэж байгаад бас нас барчихлаа .Тэр манийн үеийн хүн байсан.Тэгээд Мятавдорж их хампан байсан Дундговь дээр байсан Батшир хурандаа гэж.Тэр хурандаа бол Өмнөговьд хэлтэст байж байхдаа тэр хоёр хүнийг бол босоогоор нь тэгж алж байсан гэж ярьж байсан.Мятавдорж үеийн хүн болоод ярьж байсан, дуулсан.Тэгээд би тийм юм дуулсан, та академич хүн мэдэх үү, энийг бас судлууштай манай говьд сум даадаггүй хоёр хүн байсан , та энийг босоо санжид гэж мэдэхгүй юу гэж.Би энэ говийн Сандуй баатар гэлүү нэг сум даадаггүй хүн байсан гэж дуулсан.Хүүе босоо Санжид тэр чинь гэж Батням надад хэлж байсан.Тэгээд гурван хүн тийм байсан.дандаа хийд бараадаж байсан.Тэр Чүлтэмдорж ямар учиртай юм гэвэл Олдохын хийдийн лам, зүүнтээ одоо өргөрөг зэрэгтээ байгаа Олдохын хийдийн лам.Тэгээд энэ шашинтай хобоотой юм ны цаана чадалтай хобоотой ном сурах, тэр нэг л мөрийн юм л даа.Элдэв бусармаг юм дарна , нэгдугаарт.Хоёрдугаарт өрдөө ном сурна, гуравдугаарт бороо хур оруулна.Тэгээд л одоо тэр сум мумнаас зайлуулна, хий салхинаас зайлуулна тэр бүх юм чинь бас номтой эрдэмтэй юмтай холбоотой юм.Хийдүүд одоо байж гэдгийг олох , ном эрдэм байж гэдгийг бодох нэг явдал байна. Энэ чинь хоёр сувгийн юм байгаа юм.Тэрний цаана ямар лам ямар увидастай байсан...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Хийдийн эзэн?

Батхүү:Тийм, хийдийн эзэн .Тэгээд тэр одоо ямар багш ямар шавьд сайн ном сургасан.Багшийн эрдэм, биш ээ шавийн эрдэм багшаас илүү гэдэг үг бий.Энэ чинь монголын зүйр үгэнд байгаа.Тэр чинь сайн сураад л байвал багшаасаа давуу сураад л байдаг байх нь байна ш дээ.Тэгэхээр энэ эрдэм зүгээр газар шороо, за яахав байгаль эхтэй байгаа л байна.Байгалийн төрх намба ч одоо их л зураг хөрөгтэй байгаа юм.Цаана тэр жинхэнэ үг уурхайг нь олж авахад бол үндэсний тэр номыг нь олж авах хэрэгтэй.Энийг би зүгээр юм уу л гэж бодож байгаа юм.

Гантулга: Энэ одоо энэ...?

Батхүү:Түүхтэй ч холбоотой юм, сүм хийдтэй ч холбоотой юм.Тэгээд тэр чинь одоо Байшинтын хийдийн лам байж, Олдохын Чүлтэмдоржийг бол арван гуравтай байхад нь хуйхий цэрэг авчраад, хуйхий цэрэг гэж монголыг дайчилж байсан юм байна. Тэрүүний хоёр нь ирээд , орон гэр нүүгээд явчихсан, улс чинь нүүгээд явчихсан, эх нь өвчтэй.Хийд, Олдохын хийд дээр одоо эхийгээ хараад байж байгаа жаал муу бандийг хоёр хүн гаргаж ирээд, зогсож байгаад хоёр буудчихсан.Тэгсэн мань хүн тэр суусан хүүхэд ойчоогүй, сууж байгаад нэг нэг буудсан ойчоогүй.Хэвтэж байгаад нэг нэг буудсан, ойчоогүй.зургаа буудчихаад босоод ирсэн, сүм даагаагүй нэвтрээгүй тэгээд хөтөлж авчраад чавганцад танай хүүхэд ёстой мундаг ийм гэж хэлсэн юм гэнэлээ тэрнийг бол энэ Мятавдорж надад юугаа ярихав би бага байсан гэхдээ бол би энэ урд бригадын дарга байсан. Тэхэд Мятавдорж ирээд Дамбажаа гэдэг өвгөнд Мятавдоржийн зээ хүүхэн нь Дамбажаа өвгөний хүүтэй суусан Гармаагийнх гэдэг айлд бид хоёр хамт хонохдоо Дамбажаа гуайд ярьж байсныг би хажуугаас нь сонссон юм. / хөхрөлдөв./ Энийг тэгээд яахав юм болог гээд тэр академик яахав түүхийн талаасаа холбогдолтой би бол юм бичдэггүй хүн үзсэн дуулснаа энд тэнд үгээр элдэв бусын юм хэлээд явбал бас хүний удам угсаа элдэв бусын юм хэлдэг удаатай. Манай эцгийн эцэг малчин Авирмэд гээд улсын 4 удаагийн малчдын зөвлөгөөнд оролцсон хөдөлмөрийн гавьяаны одон 1, адтан гадас одон 4тэй явсан ийм буурал байсан.

Гантулга: Энэ хуйхий цэрэг гэснээс голын наана өвгөн хийдийн түүрь гээд нэг байсан байна

Батхүү: Өвгөн хүрээ юу?

Гантулга: Тийм өвгөн хүрээ энэ хуйхий цэрэг хоёрын хооронд ямар холбоо байна энэ аль цаг үеийн юм бэ?

Батхүү: Хуйхий цэргийн дайнд явж байсан гэж энэ зүүнтийшээ л болж байсан шиг байгаа юм өөрөөр хэлбэл энэ зүүн Дорнод аймгийн нутагаад юмуудаа би зүгээр хүний ярихыг сонсож байсан хуйхий цэргийн дайнд ороод бид буцаж явахад гэж энэ зүүн цохионы цаана шувуун Дэмбэрэл гэж байсан одоо энд Шархүү гэж жолооч 70 гаруй насны хүн бий тэрний эцэг холдог Сэрээ гэж хүн байлаа. Сэрээ гуай ярьж байсан Хуйхий цэргийн дайнд явж байгаад шувуун Дэмбэрэл нэг удаа айлын тойны морь нөгөө өртөөгөөр явж байхдаа барьж унасан тухай адуугаа хураагаад ир гэж гэнэ өмнөговийн цэргүүд дайнд ороод буцаж яваа тэгсэн олон адуу л хураагаад бариад байж тэгсэн сулдаа жороолоод байдаг нэг их сайхан дэл намирсан цавдир морь цагаан загал морь хоёр хэдэн бүдүүн адуутай тойроод хураагаад бусдаас нь барьж цэргүүдэд эмээллээд байх юм гэнэ. Тэгтэл шувуун Дэмбэрэл нэлээд балмад ч хүн байсан гэсэн хүү нь бийдээ одоо хотод Хайсандай гэж нийтийн хоолны газар трестийн талын дэд эрдэмтэн ч болоод байлуу яалаа манай энд сургуульд байсан юм Тэгсэн нөгөө

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

шувуун Дэмбэрэл хөөе тэр цавдир морь бариад ир гэж гэнэ хүн унадаггүй юм гэж гэнэ тэгвэл тэр зээрд морь бариад ир гэж гэнэ хүн унадаггүй юмаа гэж тэгээд юу унадаг юм бэ тойн унадаг юм тойн чинь хүн биш юмуу дуугай бариад ир гэж гэнэ. Уургач нь бариад өгч өөрөө эмээллээд унаж хөөе тэр бор морь бариад ир гээд бариад ирэхээр нь Сэрээдээ хоёулаа нэлээд үерхдэг байсан биз чи энийг уна гээд эмээлчихээд байж байтал гэрээс нэг мундаг тарган шар лам алхаж байсан нөгөө тойн нь байж . Тэр тойн гэдэг чинь хошуу ноёны ах нь ч юмуу дүү нь ч юмуу ламын тойн гэж тэгсэн бариад авсан цулбуураас нь шүүрээд авлаа гэнэ за хүү минь би унадаг юм гэж нэг татаадхсан наад өвгөн үхас гэж байна гэнэ нэлээд ч бяр чадалтай далчиганасан хар хүн хар өвгөн байсандаа шувуун Дэмбэрэл гэж алгадчихдаг гэнэ цаашаа үсрээд өгсөн босоод ирсэн хамраас нь юмуу нүүрнээс нь юмуу цус гарч байна гэнэ хөөе бушуу мордоорой та нар нэг юм болно шүү болно шүү л гэж гэнэ мордоод тавьчихсан дараачийн өртөөн дээр очоод морьдыг тавиад буцаагаад хөөчихсөн тэгээд зүгээр болж байсан тэгж л хуйхий цэргийн дайнд явж байж билээ гэж Сэрээ гуайгаас сонссон .

Гантулга: Хуйхий цэргийн дайнд явлаа гэхээр өөрсдөө оролцож явсануу хуйхий цэргийг хөөж байсан юм болуу?

Батхүү: Хуйхий цэргийг л хядаж явсан байхгүй юу эндээс тэр Жавын Сандаг гэж хүн оролцож явсан гэж байгаа юм Дожоохүү гэж байсан тэр бас

Гантулга: Тэр хүмүүсийнх нь насаар хөөгөөд бодохоор тэр нь хэдий оны үед болсон байхав ?

Батхүү: Хэн мэдэхвэ дээ ямар ч байсан татахгүй 90 хүрсэн л улсууд байсан байх тэгээд хорин хэдтэй байснау тэгж бодоход чинь 100д жилийн өмнийн юм 120д ч юмуу жилийн өмнөх үе тим л улсууд болж таараад байна. Хуйхий цэргийн дайнд тэгж оролцож явсан удаатай юм гэнэлээ сум даадаггүй тийм 3 баатар говьд байсан удаатай юм ном эрдмийн нь хувьд бол ийм юм хийд барилгын нь хувьд бол яахавдээ нэг чиглэлийн нэг хэвийн л юм тэгээд ер нь монголд дэлгэрч байсан шарын шашин л байна.

Гантулга: Шар хулстын хийд дээр түрүүн Дамдин гуай ярилаа Азар гээд энэ дооромбо лам гээд түвд ч юмуу гаднын номтой чадалтай лам нар байсан талаар тэгэхэр түвдийн хийдүүдтэй холбоотой байсан байж таарах нээ?

Батхүү: Байсан л байж таарах байх

Гантулга: Энэ талаар сонссон зүйлээсээ ярьж өгөөч ?

Батхүү: Байхгүй. Тэр талаар байхгүй. Би зүгээр энэний ганц гол дамжуулдаг юм нь ачаа тээш аянчны замаар дамждаг байснаас өшөөгөөр ер нь монголд за яахав бадарчин лам нарын ямар ч байсан 70 хувь нь рдэм түгээх сурах зорилгоор гадаад дотоод их явдаг за 30 хувь нь ч ямар ч зорилгогүй за тэгээд идэш тэжээл авгай хүүхэд эрдэг юмуу тиймэрхүү л нэг тэнэг тийм явсан. Манай эндээс ямар сайндаа Нямдорж гэдэг хүн бадарчин болох сайхан юм байна гээд хангайд очоод хангай руу явчиж 20иод настай залуухан хүү тэгсэн нэг айлын найр дээр ордог юм байна нэг зэлуу хүүхэн нэг их сайхан дуулсан гэж байгаа тэгсэн орон нутаг маш их санагдсан тэгээд буцаад ирсэн тэгээд дахиж яваагүй гэж байгаа. / хөхрөв/ Тэгэхээр чинь хүн нөгөө уярах юм байдаг л байна л даа нөгөө цаанаа зорилго багатай явсан учраас.

Гантулга: Энэ Хулстын хийд маань тэгэхээр шарын шашны л хийд болох нь ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батхүү: Өө шарын шашны. Шарын шашнаас ер монголын хийдүүдийн гол нь мултрахгүй байхаа гэж санадаг шүүдээ зүгээр зорилго чиглэл нь яриа хөөрөө нь

Гантулга: Одоо энэ Хулстын хийдийнхээ ойролцоо цогчин дуган ойролцоо эргэн тойронд нь сүмхийд жас байсан гэж байна. Тр талаараа яривал ?

Батхүү: Өө тэр ер нь хийд байгуулахад юу юу ордог вэ одоогийнхоор бол хамгийн хялбарчилахад сүм байгуулахад хамгийн түрүүнд захиргаа болно биз тэрний дараа бол худалдааны байгууллага орох юм байгаа биз тэгээд тухайн худалдааны байгууллага хүний хэрэгцээ энэ нь шиг л тэгээд сүүлийн үед бол энэ сургууль орох юм байгаа биз гэх мэтчилэнгийн л юм байх байлгүй тэхдээ дээр үеийн энэ жас хийдэд бол тийм бөөгнөрсөн шарын шашны сургууль маягийн юм байгаагүй гэдгийг л нэг ойлгоод байгаа юм. Хүн тус бүр нь шавьтай болоод тэрнийгээ зарах зарим нь зодож жанчиж алдаг ч байсан явдал байж л дээ. Чи юм сурдаггүй муу сурлаа энэ тэр гээд

Гантулга : Цогчин дуганыг барьсан тэр материал дотно засал чимэглэл энэ талаар зүгээр бага байхдаа үзсэн юмуу эсвэл хөгшчүүлийн ярианаас юмуу эсвэл таныг идэр залуу болсон байхад чинь үлдэгдэл мүлдэгдэл юмнаас нь харсан барьсан ?

Батхүү: Ийм юм л даа

Гантулга: Зүгээр барилгын материалынх нь талаас яривал?

Батхүү: Барилгын материал энэ хятад зөн гэдэг бол тэндээс тээгдэж ирж байсан боловуу гэж хятад зөн одоо туйпуу

Гантулга: Хөх туйпуу ? Хаанаас ?

Батхүү: Хятадаас ирж байсан боловуу гэж боддог юм зүгээр сайн мэдэхгүй аа харин энэ зөн барилгыг гагнадаг юм бол шохой шохойгоор гагнадаг одоо энэ цемент биш одоогийн юман дотор ч шохой бий л байх энэ шохойг орон нутагт одоо энэ ханын хийц чинь болбол шохойн чулуу энэ цагаан чулуу бол шохой аа цохионы чулуу бол боржин чулуу цохионы чулуу бол барзгар шар хад түүнийг бааюунд түлээд бааюу гэдэг чинь хятад нэр юм байгаа биздээ тэгэхээр бааюунд түлээд түүнийгээ буулгана гэж усанд хийгээд бууна гэдэг чинь усандаа дэвтээд ирэхээр шаарыг нь шүүж хаяад тэгээд бүүр олон хоног дэвтээж байгаад буусан шохой чинь цагаан цардаад өгнө түүнийгээ ямар нэг юмтай холидог байсан болуу яг ингэж шохой түрхээд л туйпуу тавиад тэр гагнаас. Энэ туйпуун барилгуудыг үзэхэд дан шохойн ханатай бий л дээ Та нар явж байгаад Эрдэнэхамбын хийдийг үзээрэй. Тэр үед нэг л үнэртэй юмтай холидог байсан байх Энэ зөнг чинь сүүлийн үед халуун авна ууна ч гэх шиг бөөрөнд сайн гэж элдэв бус л болох юм үнэн чюмуу худлаа ч юмуу бүү мэд

Гантулга: Тэгэхээр тэр туйпуу тоосгоны өрлөгийг харахад босгож 5- аар нь өрөөд ч юмуу хэвтүүлж хэд өрөөд тэр өрлөг мөрлөгийн талаар бол ?

Батхүү: үгүй энэ бол яахав зүгээр нэг эвтэйхэн сайн барьдаг уран хүн бол босгоод зөвхөн гадарлачихдаг одооны пялтаа шиг /пилта/ дотор нь шавар өрөөд тэр бол бөх тэсвэртэй гэж ярьж байсан зүгээр хавтгайгаар нь барих

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бол тэр үеийн л хэрэг байж их материал орох л юм л даа өнгөлгөөнд голдуухан хэрэглэж байсан боловчуу гэж санаж байгаа юм.

Гантулга: Суурийг нь болбол?

Батхүү: Суурийг нь болбол одоо чулуугаар хундаам хийдэг л байсан байх л даа Тэгээд хундаамаа тэр цемент гэдэг нь байсан юмуу цементийг чинь бол их дээхнэ үед аргын шал гэж байсан

Гантулга: Аа монгол нэр нь ?

Батхүү: Тийм аргын шал .

Гантулга: Аргын шал гэж юу гэсэн утга вэ?

Батхүү: Үгүй яахав дээ аргын шал гэдэг чинь ямар нэгэн эвдрэлгүй болох аль нэгэн аргаар хийсэн, шал гэдэг чинь газар шороо. Аргаар гэдэг чинь одоо монгол үг байгаа биз дээ аргаар хольцоор хийж байгуулсан зүйл ёстой тэр аргыг олж хийсэн зүйл байгаа биз дээ. Монгол үгний утганд бол их дөхүү байгаа. Энэ ч одоо яахадээ тэр гарнизыг бол нэлээн зузаанхан уртхан нэг тийм дөрвөлжин хийдэг байсан байна. Тэр гарниз/граница/ гэдэг чинь л хамгийн дээд тал тэгээд барилга бол одоогийн барилга шиг ирмэгэн дээрээ хув биш заавал гадагшаа сүүлтэй сүүлний доод тал дээр модон гарнизтай/граница/ байж.Тэр чинь ханаа дээрээсээ , ямар ч байсан метр үгүй юм аа, гэхэд тавин см хамгаалж байж.Бороо салхи эд нараас хамгаалдаг, тийм л байсан байна л даа. Хөмсөг гэсэн үг.Тэгээд тэрний үрд хийц нь бол хааш хаашаагаа нэг дөчин см юм уу даа, тийм дөрвөлжин, хавтгай тоосго одоо зөн, тэгээд дээр нь тийм бадан толгой, гинж зуучихсан бадан толгойгоор,тэгээд дээр нь товойлгочихсон. Товруу гэдэг чинь ийм гурван товруу байгаа юм, товруу гээд...Тэгээд л тэрний хооронд нэг ийм сүм шиг юмтай.Бас нэг дөчин см.Тийм хөөрхөн нэлээн зузаан тийм юм тэвхийтэл өрчихсөн.Тийм л барилга харагддаг байсан.За ер нь бол тэгээд загвар бол одоо би, үгүй ээ үгүй сайн дуган байсан л гэж замын дагуу болоод ч тэр юм уу, тэгж л боддог хүн.

Гантулга: Дамиран гуай түрүүн хэлж байсан, тэр багана нь луутай багана байсан. Хичнээн баганатай байсан юм?

Дамиран: Үгүй ээ энэ чинь нэг...

Гантулга: Олон баганатай байсан уу?

Дамиран: Өө тийм, олон баганатай байсан.

Гантулга: Луу ороосон байсан уу?

Дамиран: Дандаа л алтан луу ороочихсон.Тэгээд л тэр чинь нэг хаана нь тогтоодог юм, нэг том том хэнгэрэг, хэнгэрэг л байдаг юм.

Гантулга: Тэгээд голдоо бурхантай?

Дамиран: Тийм.

Гантулга: Тэгээд жагдан лам нь хоёр талаараа?

Дамиран: Тийм.

Батхүү: Монгол ч хийдэг юм уу, хятад ч хийдэг тэр баганы луугий чинь, одоо зүмбэр л гэж ярьдаг юм даа.Одоо юм бол будаг шавчихдагийг чинь ямар юм гэнэ лээд дээ...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Гибс?/гипс/

Батхүү: Гибс/гипс/ маягийн одоо тийм зүмбэр маягийн юм хийж байгаад л , одоо тэрийг чинь хэвэнд цутгадаг юм уу, ороож хийгээд л тэгээд л тэрнийг чинь аваачаад л алт, шармалаар будаад л , алтаа дууриачихна.Тэр зууван хэлбэрийн тэгж л ...

Гантулга: Энэ өдөр тутмынх нь хурал, тэгээд л энэ шинийн найман, арван таван дүйчэн өдрийнх нь хурал, тэгээд л янз бүрийн цам харайх , сор залах, майдар эргэх гэх мэтийн тийм шашны зан үйлүүд болдог байсан уу?

Дамиран: Байсан юм гэнэ лээ.

Батхүү. Тэр сор, майдар сор зална, сорт явна гэдгийг чинь Хошуу хийд дээр голдуу хийдэг байсан гэж байгаа юм.Одоо манай энэ баруун талынхан чинь одоо Хошуу хийдийн сорд явна гээд бөөнөөрөө хөдөлдөг байсан гэж байгаа юм.Тэгэхлээр эндээс тэр сор зална гэж байгаагүй юм болов уу гэж.

Гантулга: Аан том хурал руу?

Батхүү: Тийм.

Дамиран: Жас гэж яриад байна аа?

Гантулга: Тийм.

Дамиран: Энэ дээр болвол тэр жас бол байж.Манай тэр нэг ах болох хүн Бор Соном гэж байсан юм.Нэг өвгөн байсан юм, тэр жасын тогооч хийж байсан гэж ярьж байсан юм.Энэ Шар Хулсны хийдийн...

Гантулга: Тэгэхээр энэ дээр жас байж?

Дамиран: Тийм, жасын тогооч хийж байсан гэж...Хэдэн хүн шалгаж авсан, тогоо яг тэгшхэн тавьсныг нь авдаг байсан гэж.Тэгээд тэр манай ах, Бор Соном гэдэг хүн шалгуулсан, яг тэгшхэн тавьсан.Тэгээд жасын тогоо чболж байсан гэж ярьдаг байсан.Тэгэхээр жас бол байсан байх нь.

Гантулга: Байсан байх гээд байна, тэгэхээр?

Дамиран: Тийм.

Батхүү: Жас гэдэг чинь хийд болгонд л байдаг...

Гантулга: Аан?

Батхүү: Хийд болгонд л байдаг.

Дамиран: Хийд болгонд, жасгүй хийд гэж байхгүй.Онцгой нэгх газар биш ээ.

Гантулга: Тэгвэл цам, сор энэ тэр нь бол хойд тал руугаа явдаг байж дээ?

Батхүү: Томхон хурлууд тийм юм нь бол тийшээ явсан байх.Зүгээр нэг жижиг бага хэмжээний жас бол говьд одоо...

Дамиран: Майдар эргэнэ гэдэг бол хийд болгонд байсан юм байна ш дээ.Энэ дээр чинь одоо бас майдар эргэнэ гээд л байж.

Гантулга: Аан энэ Шар хулсан дээр үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамиран: Тэгэлгүй яахав. Майдар эргэдэг байсан гээд л манай муу эх л ярьдаг байсан.Намайг чинь жижигхэн юм чинь янз бүрийн юм ер нь их л болдог байж л дээ.Тэгээд л майдар эргэж байсан, гороо эргэж байсан гээд л ...тэгж юугаа явж байсан, ядарч байсан зарим нь энэ тэр гэж тэгж ярьдаг байсан ш дээ.

Гантулга: Аан за?

Дамиран: Зуун найм эргэж байсан энэ тэр гэж...

Гантулга: Тэр сүм хийд, одоо энэ Шар хулсны хийд хичнээн ламтай байсныг мэдэх үү?

Дамиран: Мэдэхгүй ээ.

Гантулга: Батхүү гуай?

Батхүү: Зуугаад ламтай байсан шиг байгаа юм.

Гантулга: Зуугаад аа?

Батхүү: Тийм, тийм л нэг үг байдаг юм шүү дээ.

Дамиран: Яг тэр Батхүүгийн хэлж байсан, Дамдинсүрэн гуай мэдэх байсан байх.

Гантулга: Түрүүн та хэлж байсан, тэр дацан сургуулиудаа бол хойноо хийж байсан байх гэж, тэр талаар яривал? Энэ дээрээ зурхайч сурдаг юм уу, маарамба ч сурдаг байсан юм уу, уг нь энэ том дооромбо байсан газар юм байна ш дээ?

Дамиран: Энэ дээр бол одоо яахав дээ, нэг ёсондоо бол тэр ном бясалгал төгсдөг, бага сургууль л байж л дээ.

Батхүү: Дооромбо лам гэдэг чинь ерөнхийдөө л эндхийн Дашренчин гэж хүн байгаа юм.

Гантулга: Тушаал нь л?

Батхүү: Үгүй ээ нэр нь дооромбо юм байгаа юм.

Дамиран: Тийм л улс байсан байгаа юм. Нэг үгээр хэлвэл бага сургууль л гэж..

Батхүү: Сайн л лам байсан байна л даа.

Гантулга: Юу хийж байсан энэ тэр талаар нь эндхийн лам нар явж байсан гэсэн тийм юм дуулсан талаар, Батхүү ах?

Батхүү: За тийм юм алга аа . Зүгээр тэнд л цуглаж , тэрүүнд л явдаг,Хошуу хийд дээр л цугладаг байсан.

Гантулга: Тусгай эмнэлгийн ном энэ тэр сурдаг талаар, яаж ямар хугацаатай сурдаг энэ тэр талаар бол дуулаагүй юу?

Батхүү: Үгүй ээ тэгээд